

“Монхан трейд” ХХК-д брокер, дилерийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дахь заалт болон “Монхан трейд” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Монхан трейд” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосонтой холбогдуулан зохих баримт бичгүүдэд өөрчлөлт оруулж Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэн ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Монхан трейд” ХХК /Ким Ёо Су/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г, олон нийтэд сурталчлахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ